



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ “ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, БҮТЦИЙН ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧИЙГ ШИНЭЧЛЭН
БАТЛАХ ТУХАЙ” 13 ДУГААР ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан бөгөөд уг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь төмөр замын тээврийн үйл ажиллагаатай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байна” гэж заасан.

Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагалдаж Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 72 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн баганад “20.Төмөр замын газар” гэсэн нэмэлт оруулсан.

Гэвч Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 13 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-д Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Төмөр замын газар” тусгагдаагүй орхигдсон байна.

Иймд Төмөр замын тээврийн тухай хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхлэхтэй холбогдуулан УИХ-ын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 13 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт оруулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Хоёр. Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төсөл нь Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг

шинэчлэн батлах тухай” 13 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-д Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Төмөр замын газар”-ыг нэмэхтэй холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд З заалттай байна.

Мөн тогтоолын төсөлд Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөх хугацааг зааж өгнө.

Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Тогтоолын төсөл батлагдсанаар өсөн нэмэгдсээр байгаа тээврийн хэрэгцээг хангах, төмөр замын суурь бүтцүүдийн галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах, суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч хооронд болон суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч хоорондын харилцааг зохицуулах, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, салбарын боловсон хүчнийг мэргэшүүлэх, төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний паркийг шинэчлэх, тээврийн сүлжээг өргөжүүлэх, төмөр замын чиглэлийн судалгаа, шинжилгээ, шинжлэх ухаан технологи, инновацийг нэвтрүүлэх, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, төмөр замын салбарт мөрдөх дүрэм, журам, стандартыг боловсронгуй болгох, төмөр замын тээврийн үйлчилгээнд оролцогч өмчийн олон хэлбэрийн хуулийн этгээдийн зах зээлийн өрсөлдөөний тэгш байдлыг хангах, төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байгуулагдах, Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулаг-/ийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх нөхцөл бүрдэх юм.

Дөрөв. Тогтоолын төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Хууль тогтоомжийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй болно.

---оОо---